



САНГИЙН ЯАМНЫ ТӨСВИЙН
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАРТ

**МОНГОЛ УЛСЫН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМ**

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
Барилгачдын талбай 3, Засгийн газрын XII байр,
Утас: 31 06 12, 7600 3333-1126, Факс: (976-11) 32 29 04,
И-мэйл: info@mcud.gov.mn, Вэбсайт: www.mcud.gov.mn

2022.01.13 № 3/176

танай _____-ны № _____-т

Санхүүжилтийн эрх нээлгэх тухай

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”-ийн хүрээнд хэрэгжүүлж буй “Барилгын ажилд захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх” ажлын гүйцэтгэгч “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-тай 2021 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр байгуулсан 2021/162 тоот гэрээний дагуу олгох эхний гүйцэтгэл болох 750,000,000.0 /долоон зуун тавин сая/ төгрөгийн санхүүжилтийн хүсэлтийг Төслийн нэгж болон тус яамнаас хянан баталгаажуулж холбогдох материалыг хүргүүлж байна.

Дээрх санхүүжилтийг Засгийн газрын 2021 оны 397 дугаар тогтоолын хүрээнд танай сайдын барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан тул холбогдох журмын дагуу санхүүжилтийн эрхийг нээж, хянан шийдвэрлэж өгөхийг хүсье.

Хавсралт хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



С.МАГНАЙСҮРЭН

152250664

НЭХЭМЖЛЭХ № 13381

Нэхэмжлэгч:

Байгууллагын нэр: Барилгын хөгжлийн төв
 НӨТ төлөгчийн дугаар: 5164753
 Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2
 -р хороо, Их тойруу-1,
 Утас, Факс: 326657
 Электрон шуудан:
 Төлбөр хийх хугацаа: 2022/01/31
 Банкны нэр: ХУД ХӨГЖ ТӨВ БАНК

Төлөгч:

Байгууллагын нэр: Сангийн Яам
 НӨТ төлөгчийн дугаар:
 Хаяг:
 Гэрээний дугаар:
 Нэхэмжилсэн огноо: 2022/01/31
 Дансны дугаар: 2600078536

№	Код	Бараа, ажил үйлчилгээ	Тоо хэмжээ	Нэгж	Нэгж үнэ	НӨТ-гүй дүн
1		ТХЗ-Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл	1		750,000,000.00	750,000,000.00

Мөнгөний дүн (үсгээр)

Долоон зуун тавин сая төгрөг

Бүх дүн, НӨТ-гүй: 750,000,000.00

НӨАТ (10%): 00.00

Нийт дүн: 750,000,000.00



ЕРӨНХИЙ НЯ-БО

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖИЖ БАЙГАА БАРЬЦАА ХӨРӨНГИЙН ДАНСАНД БАЙРШУУЛСАН САНХҮҮЖИЛТИЙН ЭРХ НЭЭХ МАЯГТ №2

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, байршил, хүчин чадал	Гүйцэтгэгч	Гүйцэтгэл болон баталгаагаар олгосон боловч барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан дүн	Өмнөх санхүүжилт /барьцаа хөрөнгийн данснаас гаргасан/	Одоо санхүүжих дүн	Үлдэгдэл	Эрх нээсэн огноо	Эдийн засгийн ангилал	Барьцаа чөлөөлөх данс	Тайлбар
27	IX.2.1.1	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн Монголын талын хөрөнгө оруулалт /Улсын хэмжээнд/ БНХАУ-ын зээл, "Төв цэвэрлэх байгууламж" төслийн захиалагчийн хяналт	"Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ	750,000,000.0	0	750,000,000.00	0.0	2022.01.28	ТЭЗҮ, зураг төсөл	100900011355	БХБЯ-ны ТНБД-ын 2022.01.13-ны өдрийн 3/176 тоот албан бичиг

Хянасан:

Төсвийн Хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн

Эрх нээсэн:

Төсвийн Хөрөнгө оруулалтын мэргэжилтэн Е.Ёндонсамбуу

Хүлээж авсан:

Төрийн сангийн газрын мэргэжилтэн Ч.Цэдэндорж

2022.01.28



Гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний гадаад эх үүсвэрийн санхүүжилтийн хүсэлт № 04

Захиалагч: **Барилга, хот байгуулалтын яам**
Гүйцэтгэгч: "Барилгын хөгжлийн төв"ТӨААТҮГ
Гэрээний хугацаа: 2021.09.07-2024.13.31
2022.01.11

Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний дүн	Төслийг хэрэгжүүлэгч	Нийт гүйцэтгэл	Нийт санхүүжилт	Урьд олгосон санхүүжилт	Одоо санхүүжих
БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй "Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл"-ийн барилгын ажлын Захиалагчийн техникийн хяналтын гүйцэтгэл №1	2,500,000,000	12 29/61	750,000,000	750,000,000	-	750,000,000
Төслийн /Монголын талын хөрөнгө/			750,000,000.00	750,000,000.00	-	750,000,000.00
Дүн	2,500,000,000.00		750,000,000.00	750,000,000.00	-	750,000,000.00

Хянасан:

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
бөгөөд Ерөнхий санхүүч


С.Должинсүрэн

Боловсруулсан:

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын шинжээч


Д.Баярмаа



БАРИЛГЫН АЖИЛД ЗАХИАЛАГЧИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

2021 оны 09 дүгээр
сарын 07-ны өдөр

Дугаар 2021/162

Улаанбаатар хот

Нэг талаас "Төв цэвэрлэх байгууламжийг шинээр байгуулах төслийн нэгж" /цаашид "Захиалагч" гэх/, түүнийг төлөөлж технологийн инженер Д.Анхбат, нөгөө талаас "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ /цаашид "Захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэгч" гэх/, түүнийг төлөөлж Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Г.Түвшинжаргал нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг /цаашид "гэрээ" гэх/ байгуулав.

Монгол Улсын "Барилгын тухай хууль" болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга байгууламж барихтай холбогдон Захиалагч, Захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, барилга угсралтын ажлын үе шатанд захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэхтэй холбоотой харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

Нэг. Нийтлэг заалт

1.1. Захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэгч нь БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлттэй зээлээр Улаанбаатар хотод шинээр баригдаж байгаа "Төв цэвэрлэх байгууламж"-ийн 2021-2024 онд хэрэгжих төсөл арга хэмжээнд захиалагчийн техникийн хяналтын ажлыг гүйцэтгэнэ.

1.2. Захиалагч нь 1.1 дэх хэсэгт заасан ажлыг энэхүү гэрээний хүчин төгөлдөр байх хугацаанд нь гүйцэтгүүлж, Барилгын хөгжлийн төв /цаашид "Захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэгч" гэх/-өөс тайланг сар бүр хүлээн авна.

1.3. Захиалагч нь 1.1 дэх хэсэгт заасан ажлыг Захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэгчээр гүйцэтгүүлж, энэ гэрээнд заасан техникийн хяналтын зардлыг захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэгчид шилжүүлнэ.

Хоёр. Гэрээний хугацаа

2.1. Энэхүү гэрээ нь 2021 оны 09 дүгээр сарын 07-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүчин төгөлдөр байхаар тохиролцов.

Гурав. Техникийн хяналтын зардал

3.1. Талууд техникийн хяналтын зардлыг 2,5 тэрбум (хоёр тэрбум таван зуун сая) төгрөг байхаар хоёр талаас харилцан тохиролцсон болно.

3.2. Захиалагч нь энэхүү гэрээний 2.1 дэх хэсгийн заалт хэрэгжсэн өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор гүйцэтгэгчид зардлыг хуваарийн дагуу шилжүүлнэ.

Дөрөв. Захиалагчийн эрх, үүрэг

4.1. Ажлын гүйцэтгэлийг мэргэжлийн өндөр түвшинд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцүүлэн гүйцэтгэхийг шаардах.

4.2. Төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 5-ны дотор, тайланг улирал тутамд ирүүлж байхыг шаардах.

4.3. Захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэгчийг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах.

4.4. Захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэгчийн дотоод ажилд шууд оролцохгүйгээр ажлын явц, түүний чанар, үр дүнд хяналт тавина.

4.5. Захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэгчийн ажлын хөлсийг гэрээнд заасан хугацаанд шилжүүлэх үүрэгтэй.

Тав. Захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэгчийн эрх үүрэг

5.1. Энэхүү гэрээний 1.1 дэх хэсэгт заасан ажлыг 2.1 дэх хэсэгт заасан хугацаанд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцүүлэн чанартай гүйцэтгэнэ.

5.2. Төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн мэдээ, тайланг захиалагчид гэрээний 4.1-д заасан хугацаанд гарган албан бичгээр хүргүүлэх, шаардлагатай тохиолдолд мэдээлэл гарган өгөх.

5.3. Энэхүү гэрээний 3.2 дахь хэсэгт заасан төлбөр тооцоог захиалагчаас шаардаж авах.

5.4. Захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэгчээр чиглэл бүрийн 7 инженер ажиллах бөгөөд гүйцэтгэгчээр гэрээний нөхцөл болон батлагдсан зураг төсөл, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, барилга байгууламжийн норм, нормативын баримт хүрээнд барилгын ажлыг чанартай, бүрэн хийж гүйцэтгүүлэх үүргийг хүлээнэ. Энэхүү үүрэг нь Захиалагчаас олгогдсон санхүүжилтийн хүрээнд гэрээнд тусгагдсан чиг үүргээр хязгаарлагдана.

5.5. Захиалагчтай байгуулсан гүйцэтгэгчийн хүчин төгөлдөр гэрээг үндэслэн барилгын ажлыг холбогдох дүрэм журмын дагуу зохион байгуулна.

5.6. Барилгын ажлын захиалагчийн техникийн хяналтын зардал болон бусад санхүүжилттэй холбогдолтой асуудлыг захиалагчид тавьж шийдвэрлүүлнэ.

5.7. Барилгын ажлын үе шат бүрд байнгын хяналт тавьж, зураг төсөл, норм дүрэм, стандартын шаардлагын дагуу хэмжилт шалгалт хийж, шаардлага, зөвлөмжийг барилгын ажлын тэмдэглэлд тухай бүрд тэмдэглэх, биелэлтийг тогтоосон хугацаанд гүйцэтгүүлэх, хяналт хийх бүрт барилгын техникийн баримт бичгийг шалгаж, иж бүрдлийг хангуулж үе шатны ил далд ажлын актыг баталгаажуулах, барилгын ажлын бодит гүйцэтгэсэн тоо хэмжээг тогтоож санхүүжилтийн гүйцэтгэлийг хянаж баталгаажуулж /фото зураг, гарал үүслийн гэрчилгээ, лабораторийн сорил шинжилгээний дүгнэлт/ захиалагчид тухай бүрд хүргүүлж байна.

5.8. Барилга угсралтын ажлын явцад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаанд хяналт тавьж, заавар зөвлөгөө өгч биелэлтийг хангуулж ажиллана.

5.9. Төсөл арга хэмжээний зураг төсөлд өөрчлөлт орох, зайлшгүй хийгдэх нэмэлт ажил гарсан тохиолдолд холбогдох бичиг баримтыг бүрдүүлж захиалагчид хүргүүлнэ.

5.10. Гүйцэтгэгчийн хүсэлтээр барилгын норм дүрэмд заасан магадалшгүй ажлын зардлыг захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч шийдвэрлэнэ.

5.11. Чанаргүй болон дутуу гүйцэтгэсэн зөрчил дутагдалтай барилгын ажлын талаар дүгнэлт гаргах, тогтоосон хугацаанд гүйцэтгэгчийн зардлаар засуулах, учирсан хохирлыг арилгуулах, шаардлага биелүүлээгүй тохиолдолд санхүүжилтийг зогсоох, гэрээний хариуцлагыг тооцох саналыг захиалагчид албан бичгээр хүргүүлнэ.

5.12. Барилга байгууламжийг ашиглалтад хүлээлгэн өгөх үед захиалагчийн техникийн хяналтын нэгдсэн дүгнэлтийг гаргах, Барилгын тухай хуулийн 37.1.6 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллана.

5.13. Захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэгч нь барилга байгууламжийн баримт бичгийн иж бүрдлийг шалгаж барилгын ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийг баталгаажуулна.

5.14. Захиалагчийг мэргэжлийн зөвлөгөөгөөр хангаж ажиллана.

5.15. Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад үүссэн төрийн болон албаны нууцтай холбоотой асуудлыг чанд хадгалж, энэ талаарх холбогдох хууль, тогтоомжийг мөрдлөг болгон ажиллана.

5.16. Захиалагчийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах.

Зургаа. Давагдашгүй эрх, үүрэг

6.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл /Тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр оролцоо гэх мэт/-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

6.2. Дээрх давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн асуудлыг хариуцсан төрийн захиргааны байгууллага болон төрийн бус байгууллага гэрчилнэ.

Долоо. Маргаан шийдвэрлэх журам

7.1. Гэрээний явцад талуудын хооронд үүссэн маргааныг талууд харилцан тохиролцоо замаар шийдвэрлэнэ.

7.2. Хэрэв маргаантай асуудлаар талууд тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд Монгол Улсын хууль, тогтоомжийн дагуу шүүх байгууллагаар шийдвэрлүүлнэ.

7.3. Захиалагч техникийн хяналтын зардлыг шилжүүлээгүй тохиолдолд буруутай тал харилцан 0.01%-ийн алданги төлнө.

Найм. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах.

8.1. Ажил гүйцэтгэх явцад ажлын нөхцөлд оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

Ес. Бусад заалт

9.1. Энэхүү гэрээг 4 хувь үйлдэв. Хууль зүйн хувьд тус бүр адил хүчинтэй болно.

9.2. Талуудын хамтын ажиллагааг хамтарсан журам боловсруулан хэрэгжүүлж ажиллаж болно.

ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧ:

**"ТӨВ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙГ
ШИНЭЭР БАРИХ" ТӨСЛИЙН
НЭГЖИЙН ТЕХНОЛОГИЙН
ИНЖЕНЕР**



Д.АНХБАТ

**"ТӨВ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИЙГ
ШИНЭЭР БАРИХ" ТӨСЛИЙН
НЭГЖИЙН САНХҮҮГИЙН АЖИЛТАН**



Х.ГАЛСАНХҮҮ

**ЗАХИАЛАГЧИЙН ТЕХНИКИЙН
ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:**

**"БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ"
ТӨҮГ-ЫН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА**



Т.ТҮВШИНЖАРГАЛ

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН
ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА**



Э.МӨНХСҮХ

**САНХҮҮ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА**



Г.ГАНТУУЛ

**ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ХУУЛИЙН
АЛБАНЫ ДАРГА**



Я.МӨНХ-ЭРДЭНЭ

Хаяг:

Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг,
5-р хороо Ж.Самбуугийн гудамж 24.
М плаза 1505 тоот
Утас: 77073307, 77074407
Цахим хаяг: info@ubwwtp.mn

Хаяг:

Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг,
Их тойруу-1 "Барилгын хөгжлийн төв"
Утас: 11-326657, 11-320734
Цахим хаяг: info@barilga.gov.mn
Харилцах банк: ХХБанк
Дансны дугаар: 2600078536